ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Сонгино сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** ЗАА-2026/174/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Улиастай сум
2026 он


Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа
Утас: 99993365
Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn
Аудитын менежер: Х.Болдбаатар
Утас: 99105506
Цахим хаяг: Boldbaatarkh@audit.gov.mn
Ахлах аудитор: Ц.Оюунсувд
Утас: 99076038
Цахим хаяг: oyunsuvdts@audit.gov.mn
Гэрээт аудитор: Ц.Алтантуул
Утас: 91195554 Цахим хаяг: tuul9565@gmail.com


---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт 3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл 4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан 4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан 4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан 5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан 6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан 7
3. Санхүүгийн тайлангийн тодруулга........8
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа 8
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин 10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал 10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт 11
4. Аудитын тайлан........13
4.1 Ерөнхий зүйл ........13
4.2 Материаллаг байдал ........14
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт........14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........16
5. Аудитын илрүүлэлт ........16
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ


ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Улиастай сум, Завхан аймаг 81090
Утас/Факс: 7046-36-12
Цахим шуудан: zavkhan@audit.gov.mn


2026.02.13 № 113

танай ______ -ны № ______ -т

СОНГИНО СУМЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА Д.ДАШНЯМ-д

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сонгино сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сонгино сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Сонгино сумын Эрүүл мэндийн төв нь эрүүл мэндийн даатгалын сангаас 873.9 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 11.2 сая төгрөгийн санхүүжилтийн авлагыг тооцоо нийлсэн баримтаар баталгаажуулж, санхүүгийн тайланд тусгасан байна.

Аудитын гол асуудал

Сонгино сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар өөрийн орлогыг журмын дагуу зарцуулаагүй, ажилтанд шагнал олгосон зөрчил илэрсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд төсвөөс 15.9 сая төгрөгийн хөрөнгө худалдан авч, 24.3 сая

төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.БАТ-ЭНДРАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31* *⁄төгрөгөөр⁄*

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **132,794,612.33** | **80,398,662.11** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | - | 5,696.73 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | - | 5,696.73 |
| **3121** | **Төгрөг** | - | 5,696.73 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | - | 5,696.73 |
| **33** | **АВЛАГА** | 70,515,530.26 | 11,234,400.60 |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | 70,515,530.26 | 1,238,400.60 |
| **335** | **Бусад авлага** | - | 9,996,000.00 |
| 33510 | Байгууллагаас авах авлага | - | 9,996,000.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 62,279,082.07 | 69,158,564.78 |
| **351** | **Түүхий эд материал** | 11,768,095.40 | 3,909,110.60 |
| 35130 | Эм боох материал | 11,768,095.40 | 3,909,110.60 |
| **354** | **Хангамжийн материал** | 47,650,986.67 | 62,739,454.18 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 59,800.00 | 86,400.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 836,000.00 | 100,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 955,985.00 | 1,873,058.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 45,799,201.67 | 60,679,996.18 |
| 35600 | Мал амьтад | 2,860,000.00 | 2,510,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **2,130,549,024.39** | **1,872,014,190.93** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 2,130,549,024.39 | 1,872,014,190.93 |
| **392** | **Биет хөрөнгө** | 2,112,277,024.39 | 1,853,742,190.93 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,681,757,129.00 | 1,681,757,129.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (155,866,168.92) | (186,415,470.24) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 403,349,366.47 | 214,349,366.47 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (50,874,166.77) | (69,594,040.05) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 300,781,089.06 | 313,068,164.50 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (75,527,520.28) | (114,172,323.94) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 18,330,000.00 | 27,933,900.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (10,019,404.17) | (13,184,534.81) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 18,272,000.00 | 18,272,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 18,272,000.00 | 18,272,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **2,263,343,636.72** | **1,952,412,853.04** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **2,258,994,673.09** | **1,952,412,853.04** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 2,258,994,673.09 | 1,952,412,853.04 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 143,238,920.67 | 143,238,920.67 |
| 51101 | Өмч: - төрийн | 143,238,920.67 | 143,238,920.67 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 2,102,860,359.00 | 1,796,278,538.95 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,666,131,546.96 | 2,102,860,359.00 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 436,728,812.04 | (306,581,820.05) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 12,895,393.42 | 12,895,393.42 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **2,263,343,636.72** | **1,952,412,853.04** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31* */төгрөгөөр/*

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,363,364,560.77** | **986,330,098.34** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **536,618,688.09** | **116,630,280.74** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 536,618,688.09 | 116,630,280.74 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 35,592,400.00 | 71,214,775.04 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 27,896,200.00 | 70,142,175.04 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 7,696,200.00 | 1,072,600.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 458,320,834.87 | 24,261,383.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 42,705,453.22 | 21,154,122.70 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **826,745,872.68** | **869,699,817.60** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 59,490,100.00 | 64,872,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 59,490,100.00 | 64,872,000.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 767,255,772.68 | 804,827,817.60 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | - | 155,131.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 767,255,772.68 | 804,672,686.60 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **918,095,748.73** | **1,117,900,008.09** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **918,095,748.73** | **1,117,900,008.09** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 913,569,700.53 | 1,048,011,118.77 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 491,029,339.00 | 598,210,908.00 |
| 210101 | Үндсэн цалин | 303,379,088.00 | 383,227,749.00 |
| 210102 | Нэмэгдэл | 130,623,240.00 | 161,826,952.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 12,961,000.00 | 18,018,000.00 |
| 210104 | Урамшуулал | 44,066,011.00 | 35,138,207.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 62,109,757.14 | 75,575,406.14 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 42,985,851.48 | 52,444,676.57 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,074,771.64 | 6,116,684.04 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,507,685.95 | 3,346,005.40 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,308,252.00 | 2,733,607.51 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,233,196.07 | 10,934,432.62 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 55,965,951.80 | 60,604,210.68 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,669,441.80 | 3,524,809.68 |
| 210302 | Түлш, халаалт | 52,874,910.00 | 55,657,801.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 421,600.00 | 1,421,600.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 49,868,516.53 | 50,517,674.29 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,587,000.00 | 1,285,700.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 27,456,510.20 | 26,967,078.80 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,910,000.00 | 2,032,200.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | - | 240,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 18,915,006.33 | 19,642,695.49 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | - | 350,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 120,071,360.42 | 108,440,819.50 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 112,531,070.42 | 99,387,692.50 |

| | | | |
|---|---|---|---|
| 210502 | Хоол, хүнс | 7,540,290.00 | 4,712,127.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | - | 4,341,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 16,193,600.00 | 8,740,700.00 |
| 210604 | Урсгал засвар | 16,193,600.00 | 8,740,700.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 10,482,000.00 | 10,610,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 10,482,000.00 | 10,610,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,715,338.72 | 8,895,304.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 6,906,800.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 864,000.00 | 864,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 60,000.00 | 558,930.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 174,948.72 | 290,574.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 597,500.00 | 275,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 106,133,836.92 | 126,416,096.16 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,030,200.00 | 2,697,890.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 102,103,636.92 | 123,718,206.16 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 4,526,048.20 | 69,888,889.32 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 4,000,000.00 | 69,368,000.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс узүүлэх дэмжлэг | - | 68,328,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 4,000,000.00 | 1,040,000.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | - | 520,889.32 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 520,889.32 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **445,268,812.04** | **(131,569,909.75)** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 8,540,000.00 | 175,011,910.30 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 8,540,000.00 | 175,011,910.30 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН** | (8,540,000.00) | (175,011,910.30) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **436,728,812.04** | **(306,581,820.05)** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31* *(төгрөгөөр)*

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН** | **809,030,267.42** | **1,010,191,722.30** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **35,592,400.00** | **71,214,775.04** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 35,592,400.00 | 71,214,775.04 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 35,592,400.00 | 71,214,775.04 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 27,896,200.00 | 70,142,175.04 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 7,696,200.00 | 1,072,600.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **773,437,867.42** | **938,976,947.26** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 59,490,100.00 | 64,872,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 59,490,100.00 | 64,872,000.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 713,947,767.42 | 874,104,947.26 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | - | 155,131.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 713,947,767.42 | 873,949,816.26 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **785,535,391.43** | **994,252,125.57** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **785,535,391.43** | **994,252,125.57** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **781,009,343.23** | **924,363,236.25** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 491,029,339.00 | 598,210,908.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210101 | Үндсэн цалин | 303,379,088.00 | 383,227,749.00 |
| 210102 | Нэмэгдэл | 130,623,240.00 | 161,826,952.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 12,961,000.00 | 18,018,000.00 |
| 210104 | Урамшуулал | 44,066,011.00 | 35,138,207.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 62,109,757.14 | 75,575,406.14 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 42,985,851.48 | 52,444,676.57 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,074,771.64 | 6,116,684.04 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,507,685.95 | 3,346,005.40 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,308,252.00 | 2,733,607.51 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,233,196.07 | 10,934,432.62 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 55,965,951.80 | 60,604,210.68 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,669,441.80 | 3,524,809.68 |
| 210302 | Түлш, халаалт | 52,874,910.00 | 55,657,801.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 421,600.00 | 1,421,600.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 40,475,510.20 | 41,527,578.80 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,334,000.00 | 1,526,200.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 27,431,510.20 | 26,967,078.80 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,910,000.00 | 2,032,200.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | - | 240,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 9,800,000.00 | 10,762,100.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 104,131,646.37 | 106,273,138.63 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 96,428,646.37 | 96,302,938.63 |
| 210502 | Хоол, хүнс | 5,453,000.00 | 5,629,200.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,250,000.00 | 4,341,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 12,046,100.00 | 19,822,700.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | 86,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 12,046,100.00 | 19,736,700.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 10,482,000.00 | 10,610,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 10,482,000.00 | 10,610,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,866,338.72 | 9,041,404.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 6,906,800.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 864,000.00 | 864,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 60,000.00 | 558,930.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 174,948.72 | 290,574.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 597,500.00 | 275,000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 153,500.00 | 146,100.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 2,902,700.00 | 2,697,890.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,902,700.00 | 2,697,890.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **4,526,048.20** | **69,888,889.32** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 4,000,000.00 | 69,368,000.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | 68,328,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 4,000,000.00 | 1,040,000.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | - | 520,889.32 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 520,889.32 |

| | | | |
|---|---|---|---|
| 3 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **23,494,875.99** | **15,939,596.73** |
| 5 | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **45,308,000.00** | **15,933,900.00** |
| 22 | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **45,308,000.00** | **15,933,900.00** |
| 2200 | **Дотоод эх үүсвэрээр** | 45,308,000.00 | 15,933,900.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 45,308,000.00 | 15,933,900.00 |
| 6 | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(45,308,000.00)** | **(15,933,900.00)** |
| 8 | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | (21,813,124.01) | 5,696.73 |
| 10 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | 5,696.73 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2025 о ны 12 дугаар сарын 31* *(төгрөгөөр)*

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 143,238,920.67 | 12,967,620.82 | 1,666,059,319.56 | 1,822,265,861.05 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 72,227.40 | 72,227.40 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **143,238,920.67** | **12,967,620.82** | **1,666,131,546.96** | 1,822,338,088.45 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 0.00 | -72,227.40 | 0.00 | -72,227.40 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 436,728,812.04 | 436,728,812.04 |
| C08 | **2024оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **143,238,920.67** | **12,895,393.42** | **2,102,860,359.00** | 2,258,994,673.09 |
| D01 | **2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **143,238,920.67** | **12,895,393.42** | **2,102,860,359.00** | 2,258,994,673.09 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **143,238,920.67** | **12,895,393.42** | **2,102,860,359.00** | 2,258,994,673.09 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | -306,581,820.05 | -306,581,820.05 |
| D09 | **2025оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **143,238,920.67** | **12,895,393.42** | **1,796,278,538.95** | 1,952,412,853.04 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31* *(төгрөгөөр)*

| ЭЗА | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 987,386,400.00 | 945,314,025.57 |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 987,386,400.00 | 945,314,025.57 |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 917,058,400.00 | 875,946,025.57 |
| 2101 | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 611,896,600.00 | 598,210,908.00 |
| 210101 | Үндсэн цалин | 417,400,200.00 | 383,227,749.00 |
| 210102 | Нэмэгдэл | 141,179,200.00 | 161,826,952.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 5,317,200.00 | 18,018,000.00 |
| 210104 | Урамшуулал | 48,000,000.00 | 35,138,207.00 |
| 2102 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 75,579,100.00 | 75,575,406.14 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 51,149,600.00 | 52,444,676.57 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,107,300.00 | 6,116,684.04 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,053,700.00 | 3,346,005.40 |

| | | | |
|---|---|---|---|
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,053,700.00 | 2,733,607.51 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,214,800.00 | 10,934,432.62 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 52,676,200.00 | 41,527,578.80 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,534,000.00 | 1,526,200.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 34,081,600.00 | 26,967,078.80 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,585,000.00 | 2,032,200.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 775,600.00 | 240,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 11,700,000.00 | 10,762,100.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 113,955,600.00 | 109,123,138.63 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 98,402,600.00 | 99,152,938.63 |
| 210502 | Хоол, хүнс | 10,153,000.00 | 5,629,200.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 5,400,000.00 | 4,341,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 34,493,900.00 | 29,159,700.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 13,500,000.00 | 8,915,900.00 |
| 210602 | Тавилга | 5,000,000.00 | 4,254,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 15,993,900.00 | 15,989,800.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 13,100,000.00 | 10,610,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 13,100,000.00 | 10,610,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 11,206,200.00 | 9,041,404.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 7,263,300.00 | 6,906,800.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,040,000.00 | 864,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 560,000.00 | 558,930.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 448,000.00 | 290,574.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 542,900.00 | 275,000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 1,053,000.00 | 146,100.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 4,150,800.00 | 2,697,890.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,150,800.00 | 2,697,890.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 70,328,000.00 | 69,368,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 70,328,000.00 | 69,368,000.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 68,328,000.00 | 68,328,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,000,000.00 | 1,040,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 918,278,200.00 | 874,104,947.26 |
| **122** | **ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ** | 918,278,200.00 | 874,104,947.26 |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 918,278,200.00 | 874,104,947.26 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | 5,696.73 |

## 2.5 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31* *\/төгрөгөөр/*

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **64,872,000.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **64,872,000.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 64,351,110.68 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 60,604,210.68 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,524,809.68 |
| 210302 | Түлш, халаалт | 55,657,801.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,421,600.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,746,900.00 |

| | | |
|---|---|---|
| 210604 | Урсгал засвар | 3,746,900.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 520,889.32 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **520,889.32** |
| 213503 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг | 520,889.32 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 64,872,000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 64,872,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 64,872,000.00 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

***Сонгино сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны чиглэл:***

- *Иргэдэд эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх*

***Сонгино сумын Эрүүл мэндийн төвийн зорилго:*** Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг стандартын дагуу аюулгүй, эрсдэлгүй орчинд чанарын өндөр түвшинд, ил тод, шуурхай, хүртээмжтэй үзүүлэхийн зэрэгцээ орчин үеийн оношилгоо, эмчилгээг үйлчилгээндээ нэвтрүүлж ажиллах зорилго зорилтын хүрээнд ажилладаг байна.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зорилтын хүрээнд 44 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 95.3 хувийн гүйцэтгэлтэй гэж үнэлсэн байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

***Сонгино сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаанд мөрддөг хууль:***

1. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
2. Төрийн албаны тухай хууль
3. Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль
4. Төсвийн тухай хууль
5. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
6. Нийгмийн даатгалын ерөнхий хууль
7. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
8. Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
9. Хөдөлмөрийн тухай хууль
10. Эрүүл мэндийн даатгалын тухай хууль
11. Эрүүл мэндийн тухай хууль
12. НЭМ-ийн тусламж үйлчилгээний тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

**Байгууллагын дотоод хяналтын талаар:** Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ. Дотоод хяналтын багийг байгуулж, төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. Мөн Санхүүгийн өдөр тутмын ажил гүйлгээнд байгууллагын дарга, санхүүгийн албаны дарга, төсөв, төрийн сангийн мэргэжилтэн нар хяналтыг хийж байна.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сонгино сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна.Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сонгино сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө өмнөх оноос 310,930.78 мянган төгрөгөөр буюу 13 хувиар буурсан байна.

***Хүснэгт 1.*** *Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

*/мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Төрийн сангийн харилцах | | 5.70 | 5.70 |
| Авлага | 70,515.53 | 11,234.40 | (59,281.13) |
| Бараа материал | 62,279.08 | 69,158.56 | 6,879.48 |
| Үндсэн хөрөнгө | 2,130,549.02 | 1,872,014.19 | (258,534.83) |
| Нийт хөрөнгө | 2,263,343.64 | 1,952,412.85 | (310,930.78) |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 2,263,343.64 | 1,952,412.85 | (310,930.78) |
| Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн | 2,263,343.64 | 1,952,412.85 | (310,930.78) |

Санхүүгийн тайлангийн тодруулгыг мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр гэсэн данс бүрээр холбогдох журам, зааврын дагуу бэлтгэсэн байна.

**Тайланд онд:**

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 5.7 мянган төгрөгөөр өссөн байна.
Авлагын үлдэгдэл 59,281.13 мянган төгрөгөөр буурсан нь барагдуулалттай холбоотой байна.
Бараа материалын үлдэгдэл 6,879.48 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 151,152.3 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 165,426.4 мянган төгрөгийн бараа материал зарцуусантай холбоотой байна.
Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 258,534.83 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн 15,933.9 мянган төгрөгөөр хөрөнгө худалдан авч, хөрөнгө оруулалт болон хандиваар ирсэн 24,261.4 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэн, 207,651.0 мянган төгрөгийн хөрөнгө данснаас хасаж элэгдэл тооцсонтой холбоотой байна.
Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 310,930.78 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 978,278.2 мянган төгрөг, нийт зарлагыг 978,278.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант хугацаанд эрүүл мэндийн даатгалын сангаас 874,104.9 мянган төгрөг, өөрийн орлого 71,214.7 мянган төгрөг, нийт 945,319.6 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна. Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 945,314.0 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байна

***Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл***

*/мянган төгрөгөөр/*

| Хөтөлбөр арга хэмжээ | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| **Эрүүл мэндийн даатгалаас санхүүжих** | | | | | |
| **71602** | **Эмнэлгийн тусламж үйлчилгээ** | | | | |
| 80302 | Нэг иргэнд ногдох нормативаар тооцсон зардал | 945,319.6 | 945,314.0 | 5.6 | 99.9% |
| **НИЙТ** | | **945,319.6** | **945,314.0** | **5.6** | **99.9%** |

*Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.*

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн хувьд 64,872.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлснээс 60,604.2 мянган төгрөгийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд, 3,746.0 мянган төгрөгийг урсгал засварын зардалд зарцуулж, үлдэгдэл 520.8 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

### 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар

*/мянган төгрөгөөр/*

| **№** | **Худалдан авах ажиллагаа зохион байгуулсан арга** | **Бараа ажил үйлчилгээний нэр** | **Төлөвлөлт** | **Гүйцэтгэл** |
|---|---|---|---|---|
| 1 | Шууд гэрээ байгуулах | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 98,402.60 | 99,152.90 |
| 2 | Шууд гэрээ байгуулах | Хоол, хүнс | 10,153.00 | 5,629.20 |
| 3 | | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 5,400.00 | 4,341.00 |

| ДҮН | 113,955.60 | 109,123.10 |
|---|---|---|

Тайлант оны худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримталсан байна. Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчилтэй зүйл илрээгүй болно.

**3.5.6 Ерөнхий чиглэлийн хүрээнд авч хэрэгжүүлсэн судалгааны үр дүн:**

Сонгино сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар 8 чиглэлээр судалгаа авч, үр дүнг тайланд тусгалаа.

- **Унаа, хоолны хөнгөлөлтийн зардлын тарифын судалгаа:** Тус байгууллага нь 2025 онд хоолны хөнгөлөлтөд 5,317.2 мянган төгрөгийг төсөвлөж, 18,018.0 мянган төгрөгийг зарцуулсан байна. Байгууллагын дотоод журманд заасны дагуу өдрийн тарифыг 5.0 мянган төгрөгөөр тогтоосон байна.
- **Программ хангамжийн бүртгэл, тайлагналтай холбоотой судалгаа:** Тус байгууллагад 2025 оны жилийн эцсийн байдлаар бүртгэлтэй программ хангамж байхгүй байна.
- Бусад 6 чиглэлийн судалгаа нь тухайн байгууллагын үйл ажиллагаанд хамааралгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Сонгино сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг "Сүлд аудит" ХХК-ийн гэрээт аудитор Ц.Алтантуул гүйцэтгэж, хяналтыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Оюунсувд, аудитын менежер Х.Болдбаатар, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сонгино сумын Эрүүл мэндийн төв нь 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 02 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "Дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг 918,095.7 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 13,771.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 10,328.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзэн, 2025 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,117,900,0 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 16,768,5 мянган

төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 12,576,3 мянган төгрөгөөр тогтоосон.

**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шалгуур үзүүлэлтээс тухайн шалгагдагч байгууллагатай хамааралтай 33 заалтыг сонгож, горим сорил хэрэгжүүлсэн бөгөөд алдаа, зөрчил илрээгүй байна.

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Байгууллагын 2025 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

**4.5.1 Завсрын аудитын талаар**

Сонгино сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

**4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

*/мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | | | | | |
| Албан шаардлага | | | | | |
| Зөвлөмж | | | | | |
| **Нийт дүн** | | | | | |

**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар анхаарах асуудал тодорхойлогдоогүй байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 501,188.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрч, 499,948.9 мянган төгрөгийн алдааг залруулж, 200.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1,040.0 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүллээ.

**Залруулсан алдаа:**

Мөнгөн гүйлгээний журналд 482,065.6 мянган төгрөгийн цалингийн бичилтүүдийг буруу бүртгэсэн, мөнгөн гүйлгээний тайланд хөрөнгийн 15,933.9 мянган төгрөгийн зардлыг тусгаж, тайлагнаагүй, хөрөнгө оруулалтаар ирсэн 1,949.4 мянган төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4-д "Төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүрээр, санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг улирал, хагас жил, бүтэн жилээр бэлтгэж, тайлагнана.", 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө", 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана.", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасантай нийцэхгүй, толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**5.1 Төлбөрийн акт**

Ажилтанд 200.0 мянган төгрөгийн шагнал олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

**5.2 Албан шаардлага хүргүүлээгүй**

**5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. ***Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал***

***Илрүүлэлт:*** Өөрийн орлогыг журмын дагуу зарцуулаагүй, 60 хувийг баримталгүй шагнал олгосон байна.

***Өгсөн зөвлөмж:*** Төсөвт байгууллагын өөрийн орлогыг журмын дагуу зарцуулж байх, албан хаагчдыг шагнах урамшуулах, нийгмийн асуудлыг шийдвэрлэхдээ журмын 5.2 дахь заалтыг баримтлах;

Энэхүү зөвлөмжийг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт заасны дагуу төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 15-ны дотор ирүүлнэ үү.

Нийт илрүүлсэн 1,240.0 мянган төгрөгийн зөрчил нь материаллаг түвшинээс бага тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт хүргүүллээ.

**Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.**

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

*/мянган төгрөгөөр/*

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруу-лаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Мөнгөн гүйлгээний журналд цалингийн бичилтүүдийг буруу бүртгэсэн. | 1 | 482,065.6 | | | 1 | 482,065.6 | 1 | 482,065.6 | | | | |
| Мөнгөн гүйлгээний тайланд хөрөнгийн зардал буруу тусгасан | 1 | 15,933.9 | | | 1 | 15,933.9 | 1 | 15,933.9 | | | | |
| Хөрөнгө оруулалтаар ирсэн хөрөнгийг данс бүртгэлд дутуу тусгасан. | 1 | 1,949.4 | | | 1 | 1,949.4 | 1 | 1,949.4 | | | | |
| **Дүн** | **3** | **499,948.9** | | | **3** | **499,948.9** | **3** | **499,948.9** | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

*/мянган төгрөгөөр/*

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | АТТ | Тоо | Дүн |
| Ажилтанд 200.0 мянган төгрөгийн тэтгэмж олгосон | 1 | 200.0 | 1 | 200.0 | | | | | | | | |
| Өөрийн орлогын 60 хувийг зарцуулах журмыг зөрчин шагнал олгосон | 1 | 1,040.0 | | | | | 1 | 1,040.0 | | | | |
| **Дүн** | **2** | **1,240.0** | **1** | **200.0** | | | **1** | **1,040.0** | | | | |

**АУДИТЫН ТАЙЛАНГ:**

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.БАТ-УНДРАА ОГНОО: 2026-02-22

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР Х.БОЛДБААТАР ОГНОО: 2026-02-22

АХЛАХ АУДИТОР Ц.ОЮУНСУВД ОГНОО: 2026-02-22

БОЛОВСРУУЛСАН:

"СҮЛД АУДИТ" ХХК-ИЙН

ГЭРЭЭТ АУДИТОР Ц.АЛТАНТУУЛ ОГНОО: 2026-02-22